



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 01

Дархан

Г  
Дархан сумын Засаг даргын 2025-2028  
оны үйл ажиллагааны хөтөлбөр  
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэхь хэсэг, 35.1.5, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсгийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

- Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- Сумын Засаг даргын 2025-2028 үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлаж, хөтөлбөрийн биелэлтийн явцыг жил бүр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлгахыг сумын Засаг дарга (Т.Тулгаа)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЭРДЭНЭЗАЯА



Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 01 дүгээр сарын 31.-ны өдрийн  
01 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт

**ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
2025-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

АГУУЛГА

НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ХОЁР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА БУСЧИЛСЭН ХӨГЖИЛ

ГУРАВ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

ДӨРӨВ: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

№	БҮЛЭГ, АНГИЛАЛ	НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	ХОЁР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА БУСЧИЛСЭН ХӨГЖИЛ	ГУРАВ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	ДӨРӨВ: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	Нийт
1	Дэд бүлэг	5	4	6	6	21
2	Зорилт	14	10	10	9	43
3	Арга хэмжээ	51	41	43	30	165

## **ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ:**

1. НҮБ-н Тогтвортой хөгжлийн 17 зорилт
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
3. “Хүнсний хувьсгал” үндэсний хөтөлбөр
4. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр
5. “Цагаан алт” хөтөлбөр
6. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
7. “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол улсын дунд хугацааны хөгжлийн бодлого
8. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”
9. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”
10. “Халамжаас хөдөлмөрт” үндэсний хөтөлбөр
11. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” үндэсний дэд хөтөлбөр
12. “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөр
13. Хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний II хөтөлбөр
14. “Атар-IY аян” үндэсний хөтөлбөр
15. “Мал амьтны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр
16. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
17. “Монгол Улсын “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
18. Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр
19. Ардчилсан намын мөрийн хөтөлбөр
20. “Дархан-Уул аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
21. “Дархан-Уул аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
22. “Эрүүл шүд” аймгийн дэд хөтөлбөр
23. “Оюунлаг Дарханчууд” аймгийн дэд хөтөлбөр
24. “Эрүүл Дарханчууд” аймгийн дэд хөтөлбөр
25. “Сүрьеэгүй Дарханчууд” аймгийн дэд хөтөлбөр
26. “Боловсрол-2032” аймгийн дэд хөтөлбөр
27. “Утаагүй Дархан” аймгийн дэд хөтөлбөр
28. “Шарилжгүй Дархан” аймгийн дэд хөтөлбөр
29. “Цэвэр хот” аймгийн дэд хөтөлбөр
30. “Тохилог орчин-эко хороолол” аймгийн дэд хөтөлбөр
31. “Ногоон Дархан-2032” аймгийн дэд хөтөлбөр
32. “Хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөө-2032” аймгийн төлөвлөгөө
33. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө” аймгийн төлөвлөгөө
34. “Эко жорлон” аймгийн дэд хөтөлбөр
35. “Хүлэмж” аймгийн дэд хөтөлбөр
36. “Нээлттэй Дархан” аймгийн дэд хөтөлбөр

## **НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Амьдралын чанарыг сайжруулах, нийгмийн тэгш байдал, тогтвортой хөгжил, нийгмийн суурь хэрэгцээг хангах замаар хүний хөгжилийг бүхэлд нь дэмжихэд чиглэсэн салбар дундын ажиллагаануудыг хэрэгжүүлнэ.

### **1.1. БОЛОВСРОЛ**

#### **1.1.1. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

1.1.1.1.Хүүхдийн хөгжлийн онцлогийг харгалзан тэгш хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зөвлөн дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

1.1.1.2.Боловсрол-2032 хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.1.1.3.Ерөнхий боловсролын сургуулийн хүчин чадал, байршил, хүүхдийн тоо сургуулийн онцлог, ирээдүйн хэрэгцээ зэрэг хүчин зүйлсийг тооцон төрөлжсөн ахлах сургуулийг байгуулж, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх ажлыг дэмжинэ.

1.1.1.4.Шинжлэх ухааны тооцоо судалгаанд тулгуурлан олон улсын хөтөлбөрүүдийг нутагшуулж, багш суралцагчдын өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогыг баримтална.

1.1.1.5.Насан туршийн суралцахуйн төвийн чанар, хүртээмжийг сайжруулна.

1.1.1.6.Их дээд, мэргэжлийн боловсролын сургуулийн үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

1.1.1.7.Боловсролын байгууллагын сургалтын орчин нөхцөлийг сайжруулна.

#### **1.1.2. Сургалтын орчин дахь хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулна.**

1.1.2.1. Хүүхдийн оролцооны хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.

1.1.2.2.Боловсролын салбарт багш, сурагчдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах төсөл, хөтөлбөр нөлөөллийн үйл ажиллагааг дэмжинэ.

1.1.2.3.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд хүнсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.2.4.Дотуур байрны хүртээмж, орчин, үйлчилгээний чанарыг сайжруулна.

#### **1.1.3.Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана.**

### **1.2 ЭРҮҮЛ МЭНД**

#### **1.2.1.Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.**

1.2.1.1.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгооны хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.2.1.2. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

1.2.1.3.Иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

#### **1.2.2. Олон улсын стандартад нийцсэн бүсийн төрөлжсөн мэргэшлийн тусlamж үйлчилгээ үзүүлэх эмнэлэгтэй болно.**

1.2.2.1.Эрүүл мэндийн байгууллагын өргөтгөл, засвар, тохижилт, орчин үеийн дэвшилтээ технологийг нэвтрүүлж, тоног төхөөрөмжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.2.2.Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулахыг дэмжинэ.

### **1.2.3. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана.**

#### **1.3. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ХАМГААЛАЛ**

/Хүн ам, нийгмийн зорилтот бүлэг/

##### **1.3.1. Салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлан гэр бүл, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.**

1.3.1.1. Гэр бүлийн оролцоо, үүрэг хариуцлагыг сайжруулж, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.3.1.2. Нийгмийн бүх орчинд хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, үр дүнд суурилсан хүүхдийн хөгжил хамгааллын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.3.1.3. Гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллын нөлөөллийн ажлыг зохион байгуулж хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.

1.3.1.4. Хүүхэд хамгааллын төсөл хөтөлбөр, арга хэмжээг дэмжинэ.

1.3.1.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх “Гэр бүлийн хөгжлийн үйлчилгээ”-г дэмжинэ.

1.3.1.6. Баг бүрд хүүхэд, гэр бүлийн, хөгжил хамгааллын асуудал хариуцсан нийгмийн ажилтныг ажиллуулна.

##### **1.3.2. Ахмад настанд үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулна.**

1.3.2.1. Ахмад настны асрамжийн төв байгуулахад бодлогоор дэмжин ажиллана.

1.3.2.2. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн төв байгуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.3.2.3. Ахмад настанд үзүүлэх бусад үйлчилгээг сайжруулна.

1.3.2.4. Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.

##### **1.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулна**

1.3.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.3.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангасан ажил олгогчийг урамшуулах бодлого хэрэгжүүлнэ.

1.3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжинэ.

##### **1.3.4. Оюутан, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг зохион байгуулна.**

1.3.4.1. Олон нийтийн үйл ажиллагаанд оюутан, залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.

1.3.4.2. Оюутан, залуучуудын хөгжлийг дэмжих төслийг хэрэгжүүлнэ.

#### **1.4 хөдөлмөр эрхлэлт**

##### **1.4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

1.4.1.1. Хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлт, инновацад суурилсан гарааны бизнесийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

- 1.4.1.2. Жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4.1.3.Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.4.1.4.Өрхийн амьжиргаа дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.4.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.1.6.Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.4.1.7.Зайнаас, цахимаар, цагаар ажиллах хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.4.1.8.Богино хугацааны сургалтаар мэргэжил, ур чадвартай ажилтныг бэлтгэн, ажлын байранд зуучилна.

## **1.5. БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ, УРЛАГ**

### **1.5.1. Нийтийн биетийн тамир, спортын хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

- 1.5.1.1. Нийтийн биетийн тамир, спортын барилга байгууламж, заал, талбайн өргөтгөл, шинэчлэлт, засвар, тохижилт, тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.5.1.2.Мэргэжлийн холбоодтой хамтран олон улсын болон улс, бүс, орон нутгийн чанартай олон төрөлт тэмцэн, уралдаан, арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.1.3.Хүн амын зорилтот бүлэг /ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/-ийн тамирчдын тоо, спортын төрлийг нэмэгдүүлж амжилтыг ахиулна.
- 1.5.1.4.Тив, дэлхий, олон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдод дэмжлэг үзүүлж, урамшуулалт олгоно.

### **1.5.2.Орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжин хөгжүүлж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

- 1.5.2.1.Үндэсний өв соёлын баялаг байдлыг олон талт агуулгаар сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулна.
- 1.5.2.2.Бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөрүүдийг дэмжин, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
- 1.5.2.3.Үндэсний бичиг үсгийн соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.5.2.4.Кино урлаг, энтертеймент үйл ажиллагааг дэмжинэ.

### **1.5.3.Мэргэжлийн соёл, урлагийн байгууллага, уран бүтээлчдийг дэмжинэ.**

- 1.5.3.1.Музей, номын сан зэрэг соёлын байгууллагын сан хөмрөгийг баяжуулж соёлын өвийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 1.5.3.2.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.
- 1.5.3.3.Мэргэжлийн уран бүтээлчдийг дэмжинэ.
- 1.5.3.4.Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлагчдыг дэмжинэ.

5 дэд бүлэг, 14 зорилт, 51 арга хэмжээ

## **ХОЁР: УХААЛАГ ХОТ БА БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй, ухаалаг дэд бүтэц бүхий хотыг хөгжүүлнэ.

## **2.1. ХҮН ТӨВТЭЙ ХОТ**

### **2.1.1. Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.**

- 2.1.1.1. Хот суурин, шинэ суурьшлын бүсийг стандартад нийцүүлэн төлөвлөнө.
- 2.1.1.2. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.
- 2.1.1.3. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана.

#### **2.1.2. Инженерийн дэд бүтцийг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.**

- 2.1.2.1. Эрчим хүчний хоёрдогч эх үүсвэртэй болохыг бодлогоор дэмжинэ.
- 2.1.2.2. Инженерийн дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлтийг хийж, ус, дулаан хангамж, эрчим хүч, цахим сүлжээний найдвартай байдлыг ханггуулна.
- 2.1.2.3. Зам, замын байгууламжийг инженерийн нэгдсэн төлөвлөлттэй уялдуулж, ус зайлзуулах шугам сүлжээг стандартын дагуу гүйцэтгүүлнэ.
- 2.1.2.4. Уер усны гамшгийн эрсдэлийг бууруулж, үерийн далан, сувгийн засвар, өргөтгөл, шинэчлэлт, арчлалт хамгаалалтын ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.1.2.5. Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.

#### **2.1.3. Авто замын сүлжээг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

- 2.1.3.1. Хотын доторх авто зам, замын байгууламж, явган хүний болон дугуйн зам, авто зогсоолыг өргөтгөн, шинэчилж, нэвтрэх чадвар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.1.3.2. Нийтийн тээврийн стандартад нийцсэн зогсоолын тоог нэмэгдүүлнэ.

#### **2.1.4. Нийтийн зориулалттай орон сууцны ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.**

- 2.1.4.1. Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.4.2. Орон сууцны инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж, ашиглалтыг сайжруулна.
- 2.1.4.3. Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, засвар, шинэчлэлт, арчлалт хамгаалалтын сайжруулж хортон шавжийг устгах ажлыг хэрэгжүүлнэ

#### **2.1.5. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.**

- 2.1.5.1. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.1.5.2. Нийтийн зориулалттай орон сууц болон гэр хорооллын айл өрхийн эрчим хүчний хэрэглээг хэмнэх, дулаан алдагдлыг бууруулах төслийг дэмжинэ.
- 2.1.5.3. Нүхэн жорлонгийн тоог багасгаж, хөрсний бохирдлыг бууруулна.
- 2.1.5.4. “Хашаандaa сайхан амьдаръя” хөтөлбөрийн хүрээнд байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих санаачилгыг дэмжинэ.

## **2.2 НОГООН ХОТ**

#### **2.2.1. Хүрээлэн буй орчныг хамгаалж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.**

- 2.2.1.1. Цөлжилт, газрын доройтлыг бууруулж, уул уурхайн нөхөн сэргээлтийг нэмэгдүүлнэ.
- 2.2.1.2. Ойг хамгаалах менежментийг сайжруулж, ойн хомсдол, доройтлыг бууруулах, ойжуулах, нөхөн сэргээх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 2.2.1.3. Ундны усны нөөцийн эх ундаргыг хамгаалж, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг эхлүүлнэ.

- 2.2.1.4.Үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан усыг дахин ашиглах технологийг хөгжүүлж, “Саарал ус”-ны хэрэглээг үе шаттайгаар нэмэгдүүлэхийг дэмжинэ.
- 2.2.1.5.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Дархан-2032” хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах хамгаалах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.2.1.6.Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн болон мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлан байгальд ээлтэй санаачлагыг сурталчилна.
- 2.2.1.7.Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана.

## **2.2.2.Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.**

- 2.2.2.1.“Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.2.2.2.“Хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөө-2032”-ын хэрэгжилтийг хангуулна.
- 2.2.2.3.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

## **2.3. УХААЛАГ ХОТ**

### **2.3.1.Их өгөгдөл ашиглан, удирдлагын нэгдсэн системийг сайжруулна.**

- 2.3.1.1.“Ногоон бус” төслийг үе шаттай хэрэгжүүлж, камерын хяналтын шуурхай удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлнэ.
- 2.3.1.2.Технологийн дэвшлийг ашиглан ундны болон ахуйн усан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.1.3.Нийтийн тээврийн хэрэгслийн байршил, зарцуулах хугацааны мэдээллийг нэгдсэн системд холбож, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### **2.3.2.Орчин үеийн дижитал шийдлүүдийг ашиглан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

- 2.3.2.1.“Кибер аюулгүй байдлын журам”-ыг мөрдүүлнэ.
- 2.3.2.2.“Нээлттэй Дархан” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.3.2.3.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн цахим хяналтыг сайжруулна.
- 2.3.2.4.“Жишиг цахим аймаг” болох бодлогын хүрээнд Төрийн байгууллагуудын ил тод байдлыг хангуулах <https://core.da.gov.mn> системийг хөгжүүлнэ.
- 2.3.2.5.Хүүхдэд зориулсан төрийн үйлчилгээ, сургалтын мэдээллийг хүргэх, хүсэлт хүлээн авах <https://kids.da.gov.mn> системийг боловсронгуй болгон хөгжүүлнэ.
- 2.3.2.6.Гамшгийн аюулт үзэгдлийн зарлан мэдээлэх <https://help.da.gov.mn> цахим системийг хөгжүүлэн нэвтрүүлнэ.
- 2.3.2.7.Хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах үйл ажиллагааг цахимжуулна.

## **2.4. БҮСИЙН ХӨГЖИЛ**

### **2.4.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутагт тохирсон бодлогыг хэрэгжүүлнэ.**

- 2.4.1.1.Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээг хөгжүүлэхэд хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.
- 2.4.1.2.“Бүсийн эмчилгээ, оношилгооны төв” байгуулахад дэмжиж ажиллана.
- 2.4.1.3.Олон улсын тэмцээн уралдаан, энтертайммент үйл ажиллагаа зохион байгуулах соёл урлагийн бус байгуулахыг дэмжиж ажиллана.
- 2.4.1.4.Залуу зохион бүтээгчид, инноваци технологи, инженерүүдийн HUB байгуулах, санаачлагыг дэмжиж ажиллана.

4 дэд бүлэг, 10 зорилт, 41 арга хэмжээ

## **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

Урт хугацааны тогтвортой ёсөлтийг хангах орон нутгийн чадавхыг сайжруулж, улсын чадавхыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

### **3.1. ТӨСӨВ САНХҮҮ**

#### **3.1.1.Төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулна.**

- 3.1.1.1.Төсвийн сахилга батыг чанд сахиж, төсвийн хяналтыг сайжруулна.
- 3.1.1.2.Төсөв, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулна.
- 3.1.1.3.Төсвийн ил тод байдлыг ханган ажиллана.
- 3.1.1.4.Орон нутгийн төсвийн тогтвортой, бие даасан байдлыг бэхжүүлж, санхүүгийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх замаар санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.
- 3.1.1.5.Татварын бааз суурийг өргөжүүлэх, татварт хамрагдалтын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.1.1.6.Сумын татварын орлого бурдүүлэлтэд хяналт тавина.
- 3.1.1.7.Санхүүгийн ажилтнуудыг төсөв, санхүүгийн удирдлага, холбогдох хууль тогтоомжийн сургалтад хамруулна.

#### **3.1.2.Төсөл, тендер, сангудаас олгох зээлийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод, нээлттэй явуулна.**

- 3.1.2.1.Тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороонд ажиллах хараат бус гишүүнийг цахим систем ашиглан сонгож, ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.
- 3.1.2.2.Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах хороонд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцуулан байгуулж, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.
- 3.1.2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг нийгэмд хүрэх үр өгөөжөөр нь эрэмбэлж, эдийн засгийн үр дүн чанар, ашиглалтад хяналт тавих замаар гүйцэтгэгч талыг хариуцлагажуулж, ажлын байр шинээр бий болгох хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

#### **3.1.3.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.**

- 3.1.3.1.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулж, санхүүгийн хараат бус байдлыг дэмжиж ажиллана.

3.1.3.2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн төрийн бодлого зохицуулалтын газрын мэргэжил арга зүйн, удирдлага дор хувьчлах ажлыг зохион байгуулна.

3.1.3.3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын холбогдох чиг үүрийн хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлээр үр өгөөжийг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.

### **3.2.БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

#### **3.2.1. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлнэ.**

3.2.1.1. Бизнесийн кластер хөгжил, экосистемийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.2.1.2. Хөрөнгө оруулалтын олон талт хэлбэрийг бодлогоор дэмжинэ.

3.2.1.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

#### **3.2.2.Худалдаа, үйлчилгээний зах зээлийг өргөжүүлнэ.**

3.2.2.1. Худалдаа, үйлчилгээний салбарт чанарын стандартыг хэрэгжүүлнэ.

3.2.2.2. Гадна талбайн худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэхэд дэмжиж ажиллана.

#### **3.2.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна.**

3.2.3.1. Шинжлэх ухааны ололт, амжилт, инновацыг нутагшуулж, их дээд сургууль, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.2.3.2. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлж, гэрээгээр гүйцэтгүүлнэ.

3.2.3.3. Орон нутагт үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд, холбоод болон хувийн хэвшилтэй хамтарч ажиллана.

### **3.3 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

#### **3.3.1.Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн онцлогт**

##### **НИЙЦСЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛНЭ.**

3.3.1.1. Жуулчдад зориулсан "Аялал жуулчлалын мэдээллийн төв" байгуулна.

3.3.1.2. Аялал жуулчлалын олон төрлийг хөгжүүлнэ.

3.3.1.3. Орон нутгийн иргэдэд зориулсан аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.3.1.4. Үндэсний болон олон улсын арга хэмжээг зохион байгуулах, дэмжих замаар аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.3.1.5. Зочид буудал, зоогийн газрын менежментийг сайжруулах бодлого баримтална.

### **3.4 ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ**

#### **3.4.1. Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын бүтээгдэхүүний экспортыг дэмжинэ.**

3.4.1.1. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо хангаж, нөөцийн тогтвортой байдлыг дэмжинэ.

3.4.1.2. Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд стандартад нийцсэн арга зүйг нэвтрүүлж, хяналтыг сайжруулахыг дэмжиж ажиллана.

- 3.4.1.3. Орон нутгийн онцлогт тохирсон “Дархан брэнд” бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 3.4.1.4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах агуулах, хүлэмж, зоорины аж ахуйг хөгжүүлж, хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- 3.4.1.5. Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоодын үйл ажиллагааг дэмжинэ.
- 3.4.1.6. Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний экспортыг дэмжиж ажиллана.
- 3.4.1.7. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана.

### **3.5 ХӨДӨӨ АЖ АХУЙ**

#### **3.5.1. Хот орчмын эрчимжсэн мал, туслах аж ахуйг хөгжүүлнэ.**

- 3.5.1.1. Орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох, хот орчмын эрчимжсэн мал, туслах аж ахуй хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- 3.5.1.2. Мал, амьтны гаралтай өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт, шинжилгээг өргөжүүлж, хянах арга хэмжээг сайжруулна.
- 3.5.1.3. Эрчимжсэн мал, туслах аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулна.
- 3.5.1.4. Мал нэвтрэхийг хориглох бүс нутгийг тогтоож, мөрдөх журмыг батлуулж хэрэгжилтийг хангана.
- 3.5.1.5. Хотын төвөөс мал, туслах аж ахуйг гаргах ажлыг үргэлжлүүлнэ.

### **3.6 НОГООН ЭДИЙН ЗАСАГ**

#### **3.6.1. Төрийн ногоон худалдан авалтыг нэмэгдүүлнэ.**

- 3.6.1.1. Байгаль орчинд ээлтэй ногоон үйлдвэрлэл, үйлчилгээг бодлогоор дэмжинэ.
- 3.6.1.2. Тогтвортой ногоон хот, ногоон барилга, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг дэмжинэ.
- 3.6.1.3. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.

6 дэд бүлэг 10 зорилт 43 арга хэмжээ

### **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

#### **4.1. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

##### **4.1.1. "Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.**

- 4.1.1.1. Орон нутгийн төрийн байгууллагуудаас гаргах шийдвэрийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд нийцүүлнэ.
- 4.1.1.2. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын байрны сургалтын хөтөлбөрт “Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй”-н агуулгыг тусган, хэрэгжүүлнэ.

4.1.1.3. Соёл урлаг, спорт, ажил мэргэжлээр дамжуулан хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх, оролцоог нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

#### **4.1.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.**

- 4.1.2.1. Нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.
- 4.1.2.2. "Жаргалтай амьдрал" төвөөр дамжуулан зорилтот бүлгийн иргэдийг нийгэмшүүлэх болон бусад төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.1.2.3. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ.
- 4.1.2.4. Хууль сахиулах салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ.
- 4.1.2.5. Хорихоос суллагдсан иргэдийг нийгмийн харилцаанд ороход дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.2.6. Хорихоос өөр төрлийн шийтгэлтэй иргэдийн хөдөлмөрлөх нөхцөлөөр хангана.
- 4.1.2.7. Гэр бүл рүү чиглэсэн хуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгоно.
- 4.1.2.8. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах бодлого баримтална.

#### **4.1.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.**

- 4.1.3.1. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангана.
- 4.1.3.2. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран хууль сурталчлах цуврал нэвтрүүлэг хийнэ.

### **4.2. ТӨРИЙН БҮТЭЭМЖ**

#### **4.2.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.**

- 4.2.1.1. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн бүтээмжийн орчин үеийн арга хандлагыг бүтээлчээр хэрэгжүүлж, бус нутгийн түвшинд өрсөлдөх чадвартай болгоно.
- 4.2.1.2. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг сайжруулна.
- 4.2.1.3. "Ухаалаг Дархан" төслийг үргэлжлүүлнэ.
- 4.2.1.4. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийг цахимжуулж, эргэх холбоог сайжруулна.

### **4.3. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГАА**

#### **4.3.1. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.**

- 4.3.1.1. Төрийн албан хаагчийн ур чадварыг хөгжүүлэх, ажлын байрны эрүүл аюулгүй байдлыг ханган, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.3.1.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.3.1.3. Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг чадавхжуулж, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

#### **4.4. ГАДААД ХАРИЛЦАА**

**4.4.1. Орон нутгийн онцлогт нийцсэн гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлнэ.**

4.4.1.1. Ах дүү хотуудын уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлж, харилцан туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

4.4.1.2. Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татан, түншлэлийг дэмжиж, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг төсөл, хөтөлбөрүүдэд хамруулна.

4.4.1.3. Хүүхэд, залуучууд, мэргэжилтнүүдийг олон улсын сургалтын тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамруулна.

4.4.1.4. Олон улсын тэргүүн туршлагыг нутагшуулах олон талт арга хэмжээ, солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### **4.5. БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО**

**4.5.1. Цэргийн жинхэнэ алба хаах зөвшөөрөгдсөн хэлбэрүүдийг зохистой хэрэгжүүлнэ.**

4.5.1.1. Цэргийн алба хаах иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулж ажиллана.

4.5.1.2. Иргэнд эх оронч үзэл, хүмүүжил, үндэсний бахархал, уламжлалыг төлөвшиүүлэх, боловсрол, оюун санаа, бие бялдрыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

**4.5.2. Орон нутгийн сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ.**

4.5.2.1. Орон нутгийн хамгаалалтын нэгжүүдийн бие бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, зэвсэглэл техник, материаллаг хэрэгслийн нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангана.

#### **4.6. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**4.6.1. Сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангана.**

4.6.1.1. Гамшгаас хамгаалах алба нэгжийн бэлэн байдлыг дээшлүүлэх, сургалтын орчин нөхцөлийг сайжруулна.

4.6.1.2. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.6.1.3. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийнэ.

6 дэд бүлэг, 9 зорилт, 30 арга хэмжээ

Нийт 4 бүлэг 21 дэд бүлэг 43 зорилт 165 арга хэмжээ

---оо---

## **АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖИЖ БАЙГАА ДЭД ХӨТӨЛБӨР**

*Нийгмийн бодлогын чиглэлээр*

1. "Эрүүл шүд"
2. "Халамжаас хөдөлмөрт"
3. "Оюунлаг Дарханчууд"
4. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх"
5. "Эрүүл Дарханчууд"
6. "Сүрьеэгүй Дарханчууд"
7. "Жендерийн эрх тэгш байдлыг хангах"
8. "Хүний хөгжил"
9. "Боловсрол-2032"

*Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр*

1. "Утаагүй Дархан"
2. "Атар-IY аян"
3. "Шарилжгүй Дархан"
4. "Цэвэр хот"
5. "Мал амьтны эрүүл мэнд"
6. "Тохилог орчин-эко хороолол"
7. "Ногоон Дархан-2032"
8. "Хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөө-2032"
9. "Аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө"

*Хэрэгжүүлэх төслийн жагсаалт*

1. "Цахим сургалтын систем"
2. "Эко жорлон"
3. "Хүлэмж"
4. "Нэг зэлж, цөөн хүүхэдтэй анги"
5. "Гэрт ойр сургууль, цэцэрлэг"

---оо---